



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Г.ЦОГТГЭРЭЛИЙН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Г.Цогтгэрэл миний бие 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно.

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 4 хурал зарлагдснаас хараат бус гишүүний хувьд бүх хуралд 100% ирцтэйгээр асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон байна. Үүнд:

- 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Хүний нөөц, цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнийг томилж шинэчлэн батлав.
 - ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн хавсралтаар батлав. Банкны Гүйцэтгэх захирлаар Б.Энэрэлтийг нэр дэвшүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөхөөр холбогдох баримт бичгийг хүргүүлэхээр шийдвэрлэв.
 - Чанаргүй зээлийн үлдэгдлийг эрсдэлийн сангаас хаах асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр ХЭ-ийн ээлжит бус хурлыг 2023 оны 01 сарын 06-ны өдөр хуралдуулахаар товлон.
 - Банкны 2023 оны Бүтэц, орон тоо, цалингийн шатлалыг шинэчлэн батлав.

- Япон улс, Токио хотод төлөөлөгчийн газар байгуулахыг зөвшөөрч, тус ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн цаг тухайд нь зохион байгуулах, зохих баримт бичгийг бүрдүүлж Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.
- ДАГ-ын 2023 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар батлав.
- ТУЗ-ийн ажлын албаны хуульчийг Гүйцэтгэх удирдлагын багт шилжин ажиллахтай холбоотой үүрэгт ажлаас чөлөөлөв.

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэв. Үүнд:

- Банкны Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт өөрчлөлт хавсралтаар оруулав
- Банкны Зээлийн бодлогод хавсралт ёсоор нэмэлт өөрчлөлт оруулав
- Банкны “Тогтвортой санхүүжилтийн бодлого”-ыг хавсралт №1, “Жендерийн эрх тэгш байдлын бодлого”-ыг хавсралт №2 ёсоор тус тус батлав.
- Банкны 2023 оны Бизнес төлөвлөгөөг хавсралт №1, төсвийг хавсралт №2 ёсоор тус тус батлав.
- Банкны Гүйцэтгэх захирлаар Батболд овогтой Энэрэлтийн Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн үүрэгт ажилд томилов.
- Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 12 цагт банкны хурлын танхимд “Банкны Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцүүлэхээр хурлыг товлов.

2023 оны 03 сарын 17-ны өдрийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэв.

Үүнд:

- Банкны ХЭ-ийн ээлжит хурлыг 2023 оны 04 сарын 28-ны өдрийн 15 цагт зарлан хуралдуулахаар шийдвэрлэж тус ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
 - 2022 оны хөндлөнгийн аудитын санхүүгийн тайланг батлах тухай
 - Ногдол ашиг хуваарилах эсэх тухай
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн асуудал
 - Банкны жилийн үйл ажиллагааны талаарх дүгнэлтийг танилцуулж, батлах тухай

2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэв. Үүнд:

- Банкны МУТСТ чиглэсэн Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй танилцаж хавсралт ёсоор батлахаар шийдвэрлэв, мөн банкны Комплаенсийн бодлогыг дахин сайжруулж дараагийн хурлаар танилцуулан батлуулахыг тус тус Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.
- Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16 цагт банкны нэр дээрх тээврийн хэрэгслийг худалдан борлуулах талаарх асуудлыг хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулахаар ээлжит бус хурлыг тус банкны төв байрны 15 давхарын хурлын танхимд товлон.
- Дотоод аудитын газрын захирлыг өөрийн хүсэлтийн дагуу 2023 оны 03 сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэж, 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс дотоод аудитын газрын захирлыг шинээр томилов.
- ТУЗ-ийн 2023 оны 01 сарын 02-ны өдрийн №Т/23-01-08 дугаартай тогтоолын хавсралт №2-ын дагуу батлагдсан орон тооны нэршилд нэмэлт өөрчлөлт оруулан хавсралт ёсоор шинэчлэн батлав.
- 2023 оны 04 сарын 03-ны өдрөөс Дотоод аудитын газрын ерөнхий аудитын албаны захирлыг томилов
- Байгууллагын 2 зээлийн үндсэн зээл, хүүгийн төлбөрийг 2023 оны 03 сарын 30-ны өдрөөр дуусгавар болгон хааж, барьцаа хөрөнгийг банкны ӨБХХ дансанд бүртгэхийг зөвшөөрөв.
- Байгууллагын үндсэн зээл хүүгийн төлбөрийг 2023 оны 03 сарын 30-ны өдрөөр дуусгавар болгон хааж, барьцаа хөрөнгийг банкны ӨБХХ дансанд бүртгэхийг зөвшөөрөв.
- Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар, СТОУС-ын дагуу холбогдох тооцооллыг нарийвчлан гаргаж зөрүү төлбөр үүссэн тохиолдолд зээлдэгчээр төлүүлэх, гэрээ байгуулах, хууль эрх зүйн шаардлагыг бүрэн хангуулж ажиллахыг тус тус Гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

Тус өдрийн хурлын 8 дахь асуудлын байгууллагын зээлийн гэрээг дуусгавах болгож ӨБХХ дансанд бүртгэхийг хараат бус гишүүний хувьд банканд алдагдалтай гэж үзсэн тул дэмжээгүй татгалзсан.

2. Аудитын хороонд ажилласан тухай:

Аудитын хороо нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 3 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 1 удаа буюу 2023 оны 01 сарын 20-ны өдөр хуралдсан бөгөөд Аудитын хорооны гишүүний хувьд дотоод аудитын газрын 2022 оны ажлын тайлантай танилцаж холбогдох үүрэг даалгаварыг өгч ажилласан.

3. Эрсдэлийн удирдлагын хороонд ажилласан тухай:

Эрсдэлийн удирдлагын хороо нь 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс 03 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 1 удаа хуралдсан бөгөөд эрсдэлийн удирдлагын хорооны гишүүний хувьд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцож зөвлөмжийг хүргүүлсэн болно. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын нэгжүүдийн ажлын тайлан, 2023 оны ажлын төлөвлөгөө, Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд өөрчлөлт оруулах, Чанаргүй зээлийн 2023 оны стратеги төлөвлөгөө болон зээлийн бодлогод өөрчлөлт оруулах тухай асуудлуудтай тус тус танилцаж цаашид 2023 оны ажлын төлөвлөгөөг 2 жилээр гарган сайжруулж ажиллах, эрсдэлийн бодлого, журам заавруудыг англи хэл дээр болгохыг даалгав.
- Чанаргүй активыг бууруулах 2023 оны стратеги төлөвлөгөөтэй танилцаж, холбогдох журмын дагуу хугацаанд нь Монголбанканд хүргүүлж ажиллахыг үүрэг болгож ажилласан болно.

Тайлан бичсэн:

ТУЗ-ийн хараат бус гишүүн: *Г.Цогтсүрэн* Г.ЦОГТГЭРЭЛ